

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭН ХӨГЖҮҮЛЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ БИЙ БОЛГОХ
БАЯЛАГ БҮТЭЭГЧ-БАЯНХОНГОР ХӨТӨЛБӨР
(Шинэжинст сум)

2024 оны 06 дугаар сарын 05

Залаа

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
91	ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЖ, КЛАСТЕРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРУУЛАХ	2.2. Ашиг шимийн чиглэлээр нь төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгуудад Монгол оронд дасан зохицсон баталгаажсан үүлдэр, омгийн малаас шилэн сонгосон цөм сүргийн сайжруулагчийг үржилд ашиглан ашиг шимийг нь нэмэгдүүлнэ.	2022 - 2024			Хүнс, Хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Баянбулаг омгийн хонин сүргээс бойжуулсан шүдлэн хуц 30 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн ямаан сүргээс бойжуулсан өсвөр 30 толгой хээлтүүлэгчийг хүлээн авч малчдад гэрээлэн хээлтүүлэгт ашиглаж байна.Мөн Тогтвортой ноолуур төслийн 18 сая төгрөгийн санхүүжилтээр 130 толгой Залаажинст -Эдрэн үүлдрийн цөм сүргийн хээлтүүлэгчийг худалдан авч суурилан маллуулж байна.Улсын их хурлын даргын санаачилгаар малын чанарыг сайжруулах төслийн хүрээнд 25 толгой Баянбулаг омгийн хонин сүргээс бойжуулсан 25 толгой өсвөр хээлтүүлэгчийг хүлээн авч тээвэрлэн авчирч малчдад гэрээгээр ашиглуулж байна.	100%	100%
2	ГУРАВ. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ	3.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн, бизнесийг хөгжүүлэхэд	2022 - 2024	Уул уурхайн		Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ард иргэдийн гарааны бизнесийг дэмжих зорилгоор "Эрдэнэ Монгол" ХХК-аас нийт 100000000 (Нэг зуун сая) төгрөгийн санхүүжилттэй "Бичил зээл" хөтөлбөрийг 05 дугаар сараас хэрэгжүүлж эхлэн сумын ЖДҮ	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
	МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ	чиглэгдсэн бодлого, эрх зүйн орчныг сайжруулж, бизнес эрхлэгчдийг чадавжуулах, сургаж дадлагажуулах, судалгаа мэдээллээр хангах, үйл ажиллагааг нь сурталчлах замаар бизнесийн таатай орчныг бий болгоно.		"Эрдэнэ Монгол" ХХК - 100 000 000 төгрөг		эрхлэгчдээс төсөл хүлээн авч байна. Энэхүү хөтөлбөр нь ХААН банкаар дамжин олгогдох ба 3 жилийн хугацаатай, хүүгүй зээл юм. Бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэх сонирхол бүхий ард иргэдийг чадавхжуулах, сургаж дадлагажуулах, төсөл боловсруулах сургалтыг "Хөгжлийн шийдэл" ТББ-ын BEST хөтөлбөрийн сургагч багш нартай хамтран зохион байгуулсан. Эхийн голын Баянбүрдийн газар тариалан эрхлэгчдэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ерөнхий агрономич Б.Мөнхтогтох, Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Г.Золбоо, зөвлөх агрономич Н.Алтантуяа нар 2024 оны 04 сарын 20-ны өдөр тариалангийн талбайн ашиглалт, таримлын сэлгээ, хөрс боловсруулалт, үр суулгацын материалыг тариалалтад бэлтгэх, ургалтын үеийн технологийн мөрдөлт, усалгаа, ургамал хамгаалах химийн болон биологийн арга, химийн бодис, бордоо хэрэглэх, хөнөөлт шавж, ашигт бичил биет, хог ургамал, ургамлын өвчин зэрэг сэдвээр сургалт зохион байгуулав. Сургалтад 18 тариалан эрхлэгч хамрагдаж тариалан эрхлэхэд өөрсдөд тулгардаг асуудал, санал бодлоо солилцож зөвлөгөө авч харилцан туршлага солилцлоо. Хөдөө аж ахуйн 9 хоршоонд Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргүүлж "Цармын цагаан сувд" хоршооны дарга З.Амартүвшин, "Залаа шинэ эргэлт" хоршооны дарга О.Бямбатогоо, малчин Ш.Батнасан, "Залаажинст торгон сүрэг" хоршооны малчин Х.Дашпунцаг, "Өсөх Залаажинст" хоршооны гишүүн Ч.Уранбилэг нарыг Улаанбаатар хотод сургалтад хамруулав.		

ЗӨВ АМЬДРАЛ ДЭД ХӨТӨЛБӨР

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх	Зорилтот түвшин, үр	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгуул
-----	--------	-------------	------------------	---------------------------------	---------------------	-----------------------	-------------------	--------------------

1	2	3	4	5	6	7	8	9
				үүсвэр (сая төгрөг)	дүнгийн үзүүлэлт			лагын үнэлгээ
1	1.1. Өсвөр үе болон иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар архийг жигших сэтгэл зүйтэй болгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах	1.1.4. Цахим орчинд "Би архи хэрэглэдэггүй" challenge өрнүүлэх	2021 - 2024			Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө тусламж өгөх зорилгоор Долоо хоног бүрийн Даваа гарагт иргэдийн "мэдээллийн цаг"-ийг 2024 оны 05 дугаар сарын 13-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Мэдээллийн цагаар албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт 11 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан. Мөн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, байгууллагын дарга нартай биечлэн уулзаж, хууль эрх зүйн чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулж, хамтран ажиллах талаар уулзалт хийж 10 ширхэг гарын авлагыг тус тус тарааж өгсөн. 100 ширхэг гарын авлагыг Тээврийн үзлэгийн үеэр иргэдэд тарааж ажилласан. Гарын авлагыг хүүхэд болон том хүнд зориулсан байдлаар хүргэсэн. Мөн 3 дугаар улирлаас эхлэн "жаргалтай амьдрал" төвтэй хамтран ажиллаж 2 иргэнийг хамруулахаар төлөвлөж байна. Иргэд сургалтад хамрагдсаны дараагаар Би архи хэрэглэдэггүй challenge-ийг өрнүүлэхээр төлөвлөж байна.	90%	50%
2	2.1. Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр	2.1.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж орчиндоо айдас төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгддэг архины	2021 - 2024			Гэр бүл дэх архины хамааралтай гишүүдийг эмчлэх, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх тухай" аймгийн Засаг даргын 2024 оны А/311 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх үүднээс тус сумын 4 багийн засаг дарга, цагдаагийн хэсэг, эрүүл мэндийн төвөөс судалгаа авч нэгтгэсэн. Жаргалтай амьдрал төвийн үйл ажиллагааг танилцуулж 6 сард тус төвөөр үйлчлүүлэхээр холбон зуучилж ажиллаж байна. Тус үйлчилгээнд 5 хүн хамруулахаар төлөвлөсөн.	70%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
		хамаарал бүхий иргэдийг "Жаргалтай амьдрал төв"-д холбон зуучилж, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах.						
3	бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.	2.1.3. Архинд донтох өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах.	2021 - 2024	Сургалт лекцийн зардал 2 сая төгрөг, Засаг даргын тамгын газрын төсөвөөс		Архинд донтох өвчтэй хүн болон архины хамаарлын талаар эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, сэтгэл зүйч Г.Бандицэрэн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр "Амьдралын үнэ цэнэ" сэдвээр сургалт лекц тавьж 5 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн иргэдийн нийтийн хуралд энэ чиглэлээр мэдээлэл сургалт өгч ажилласан.	90%	70%
4	2.1. Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,	2.1.4. Архины хамаарлаа шийдвэрлэсэн болон эрсдэл бүхий хүмүүсийг дахин архи	2021 - 2024			Жаргалтай амьдрал төвийн сургалт үйлчилгээнд хамруулсны дараа нөлөөллийн ажил зохион байгуулахаар төлөвлөсөн.	50%	0%

1	2	3	4	5	6	7	8	9
	хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.	уухаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах, үүнд мэргэжлийн баг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах						

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	ХОЁР. ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОНОВЧТОЙ	2.3. Сумдуудын хогийн төвлөрсөн цэгүүдийг хог хаягдлын хуульд заасны дагуу 3 дугаар зэрэглэлд үе шаттайгаар шилжүүлэх	2021 - 2025			Тус сумын хэмжээнд "Эрдэнэмонгол" ХХК цэвэр ус зөөж унданд хэрэглэдэг учраас цэвэр ус, ундааны пябор савнууд ихээр гардаг бөгөөд түүнийг Улаанбаатар хот руу шууд ачиж тээвэрлэх ажлыг тогтмол хийж байна. Эхэнхавцгай сумын төвийн багийн нийтийн эзэмшлийн газруудын хог хаягдлын ерөнхий байдалд улирал бүрд хяналт тавьж бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулуулж хэвшсэн. 2023 онд шинээр хогийн цэг байгуулсан, 2024 онд хогийн цэгийн ашиглалтыг сайтар хангах үүднээс	90%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
						ковш трактороор 2 удаа түрэх, огшоох ажлыг гүйцэтгэлээ. Энэ ажилд Сэкер ресурсус Монголиа ХХК хамтран оролцсон. Хог ачигч машиныг засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллах нөхцөл боломжоор хангалаа. Цэвэр орчин бүрдүүлэх зорилгоор 4 дүгээр багийн Засаг даргад зөвлөмж өгсний дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах хуваарийг захирамжилж өгсөн. Бүх нийтийн их цэвэрлэгээ сар бүрийн 15-нд тогтмол хийгдэж байна.		
2	ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЖ, ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛАХ	2.6. Аймгийн төв болон сумдын оршуулгын газруудыг цэгцлэх, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон цэцэрлэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2021 - 2025			Тус сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэгжүүлэх чиглэлээр байгууллагуудад хамтран ажиллах чиглэлээр албан тоот өгч, 5 байгууллагын 120 гаруй албан хаагчид тус тус нэг нэг газрыг хариуцан мод тарих, зүлэгжүүлэх, байгууллагын гадна цэцгийн мандал байгуулах ажлыг хийж хэрэгжүүлээ. Цэцэгжүүлэх, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажилд идэвхтэй оролцуулахаар уралдаан зарлаж, урамшууллыг шийдвэрлүүлсэн байна.	70%	30%
3		2.8. Аймгийн нутаг дэвсгэрт аливаа хог хаягдал нэн ялангуяа аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл	2021 - 2025	1760000		Сумын хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгах савыг байгууллага бүр байршуулж байгаа, Эрүүл мэндийн төвийн аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгээс тээвэрлэн хүргэх аюултай хог хаягдлын устгах цэгийг шинээр байгуулж, тэмдэгжүүлж өгсөн. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2 аж ахуйн нэгжид хяналт тавьж ажиллалаа. Ангилан ялгах савнууд байршуулсан, хэрэглэж хэвшсэн, Эрдэнэмонгол ХХК энгийн хог хаягдлаа ангилан ялгах хог хаягдлын түр цэг байгуулан хуримтлуулж байна.	70%	50%

1	2	3	4	5	6	7	8	9
		ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх						
4	ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХАД ЧИГЛЭСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ	3.3. Хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, устгах, булшлах, ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн оролцоог бодлогоор дэмжих, үйлчилгээний үнэ тарифыг зөвшилцөн тогтоох	2021 - 2025			Хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, устгах, булшлах, ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн оролцоог дэмжих зорилгоор хувь иргэнтэй гэрээ байгуулан цалинжуулж ажиллуулж байна. Хог хаягдлын үйлчилгээний үнэ тарифыг зөвшилцөн өөрчлөлт оруулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн , уг тогтоолыг хууль зүйн эрх зүйн баримт бүрдүүлж ажилласан.	90%	90%
5	ДӨРӨВ. ХАТУУ, ШИНГЭН ХОГ ХАЯГДЛААС ЯЛГАРЧ БУЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙ, ТҮҮНИЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, НИЙГЭМД	4.1. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар аймгийн иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх,	2021 - 2025			Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар сумын иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг жил бүр зохион байгуулж ажиллаж байна. 2024 онд иргэдэд 2 удаагийн сургалт мэдээллийг мэдээллийн цагаар өгч нийт 500 гаруй иргэд хамрагдсан байна.	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
		дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх						
6	ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	4.5. Аймгийн хэмжээнд хоггүй шилдэг сум, баг болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах компанит ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах	2021 - 2025	400000		"Шилдэг тохижилттой байгууллага, өрх" шалгаруулах уралдааныг жилийн хугацаатай зарласан бөгөөд хэрэгжилтийг тооцох урамшуулах хугацаа болоогүй, уралдааны хувьд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод зүлэг цэцэг тарих ажлууд өрх, байгууллагууд хийж эхлээд байгаа бөгөөд 5 байгууллага, 58 өрх мод тарих ажлыг хэрэгжүүлж байгаа ажлын явцтай байна. уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийн талаар сургалтыг 2 удаа хийж 66 сурагч, 140 иргэн хамрагдсан.	90%	90%
7		4.6. Баянхонгор аймгийн Боловсролын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Насан туршийн боловсрол, Политехникийн коллеж, амьгийн хэмжээний бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг түшиглэн "Эко Баянхонгор" төслийн	2021 - 2025			Тус сумын Цэцэрлэгийн багш ажилчдаас бүрдсэн 5 хүн эко сургагч багшаар бэлтгэгдэн "Хүрэл гэрэгэ" өргөмжлөл хүртсэн бөгөөд Улаанбаттар хотод 2 удаа, гадаадад зорчиж туршлага судлах хүртэлх арга хэмжээнд оролцоод ирсэн. Цэцэрлэгийн хүүхдүүд, эцэг эхчүүдэд сургалт хийх нөлөөллийн ажлуудыг шат дараатай хийж ажиллаж байна. 2023 онд 68 иргэнд хандан сургалт сурталчилгаа явуулсан. 2024 онд Мөнгөн гэрэгэ, авах зорилго тавин ажиллаж байгаа бөгөөд цэцэрлэгийнхээ н 4 бүлгийнхээ өрөө тохижуулах ажлыг гүйцэтгэсэн байна. Шилдэг тохижилттой өрх шалгаруулах уралдаанд сургагч багш нар хамтран оролцож байна.	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
		хүрээнд "Хог хаягдлын сургагч багш" бэлтгэж, сум, баг, хэсгийн ахлагч нарт иргэдтэй хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах						
8	ДӨРӨВ. ХАТУУ, ШИНГЭН ХОГ ХАЯГДЛААС ЯЛГАРЧ БУЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙ, ТҮҮНИЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	4.7. Иргэд, олон нийтэд хог хаягдлын боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлын явц, тэргүүн туршлага болон судалгаа, мониторингийн ажлын талаар аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, интернет хуудас, бүлгүүдтэй нягт хамтран ажиллах	2021 - 2025			Байгаль хамгааллын чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 1 удаа ярилцлага өгсөн. Хог хаягдлыг дахин боловсруулах ач холбогдол сэдвээр 1 удаа сургалт мэдээллийг 160 иргэдэд хүргэж ажилласан. Сургуулийн 1 дүгээр ангийн 2 бүлгийн 66 сурагчдад Хог хаявал мал, амьтанд хэрхэн хор нөлөөтэй вэ сэдвээр сургалт хийж, ойлголт өгч ажилласан.	70%	70%

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР - АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	1. Хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх.	1.1. Төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж үр дүнг нэмэгдүүлэх, Хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх;	2020 - 2024			Тус суманд бүртгэлтэй Хөдөө аж ахуйн 9 хоршоонд Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргүүлж "Цармын цагаан сувд" хоршооны дарга З.Амартүвшин, "Залаа шинэ эргэлт" хоршооны дарга О.Бямбатоого, малчин Ш.Батнасан, "Залаажинст торгон сүрэг" хоршооны малчин Х.Дашпунцаг, "Өсөх Залаажинст" хоршооны гишүүн Ч.Уранбилэг нарыг Улаанбаатар хотод сургалтад хамрууллаа. Сургалтын үр дүнд "Өсөх Залаажинст" хоршоо нь хөнгөлөлттэй зээлд хамрагдаж үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор "Ингэний хоормог, сүү, цагаан идээ"-ний 50 сая төгрөгийн төсөл боловсруулж байна. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоолыг 469 малчин өрхийн 900 гаруй малчинд сурталчлан таниулснаар 11 гишүүнтэй 1 хоршоо байгуулагдан Мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ боловсруулах, худалдаалах төсөл боловсруулан банк руу өгөх шатандаа явж байна. Мөн 9 гишүүнтэй 1 хоршоо нэрийн баталгаажуулалтаа авсан бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлэхээр материалаа бүрдүүлж байна.	70%	70%
2	2. Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн	2.1. Хоршоог жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх	2020 - 2024	Хоршоог хөгжүүлэх сангаас 40 сая төгрөг		"Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй	70%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
		сан болон орон нутгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих				зээл олгох шийдвэр гаргаж 2023 онд 10 сая төгрөг, 2024 оны 1 сард 30 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон.		
3	бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх	2.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийн эх үүсвэрийг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэх	2020 - 2024			Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2024 оны төсөв батлах тухай" 103 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сан"-гаас 2024 онд 112215000 (Нэг зуун арван хоёр сая хоёр зуун арван таван мянга) төгрөгийн зээл олгохоор тусгаж шийдвэрлүүлсэн.	100%	100%
4		2.4. Ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн байшин барилга, объектыг хоршоодод үнэ төлбөргүй шилжүүлэх, гэрээгээр эзэмшүүлэх	2020 - 2024			Засаг даргын Тамгын газрын барилгын нэг өрөөнд "Цармын цагаан сувд" хоршоо нь үнэ төлбөргүй байрлан үйл ажиллагаагаа явуулдаг. Тус суманд өөр ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн байшин, барилга байхгүй.	100%	100%
5	2. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний	2.1. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж,	2020 - 2024			"Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд 2024 оны 01 дүгээр сард өмнөх оны дутуу санхүүжилт болох 30 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Хоршоо хөгжүүлэх сангаас олголоо. Төслийн үр дүнд 2 дугаар багийн малчин	70%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
		өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх.				Б.Отгонбаатарыг цалинжуулан цөм сүргийг маллуулж ажлын байр нэмэгдүүлсэн. Мөн Шинэ хоршооны хөдөлгөөний хүрээнд 2024 оны 06 сарын 03-нд "Алтат салхит говь" хоршоо нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан "Мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ боловсруулах, худалдах" чиглэлээр төсөл боловсруулан бэлтгэн нийлүүлэгч, үйлчлэгч, борлуулагч зэрэг 10 ажлын байр нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна.		
6	үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.	3.2. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах	2020 - 2024	Хоршоог хөгжүүлэх сан - 1156000 төгрөг		Хоршоодод болон зээлдэгчдэд дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах сургалт сурталчилгааны зардалд Хоршоог хөгжүүлэх сангаас 1156000 (Нэг сая нэг зуун тавин зургаан мянга) төгрөгийн санхүүжилтийг тусган сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилт суманд хуваарилагдаагүй. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан "Алтат салхит говь" хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор 2 вакумдан савлагч машиныг гэрээгээр хариуцуулан олголоо.	70%	70%
7		3.8. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах	2020 - 2024			"Баянговь цагаан ямаат" хоршоо, "Цармын цагаан сувд" хоршоо нь 48м.кв, "Залаа шинэ эргэлт" хоршоо нь 120м.кв бүхий түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх агуулахыг суманд өөрсдийн хөрөнгөөр барьж байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.	90%	90%
8		3.9. Хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах,	2020 - 2024			"Өсөх Залаажинст" хоршоо нь ингэний хоормогоо интернэт орчноор сурталчлан таниулж Дархан болон Улаанбаатар хот руу 2023 оны 09 дүгээр сараас 2024 оны 05 дугаар сар хүртэл сард дунджаар 500 литрийн	70%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
		туршлага судлах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах				борлуулалт хийсэн байна. "Цармын цагаан сувд" хоршоо нь "Ээлтэй баялаг" дундын хоршоонд элсэн гишүүн өрхүүдийн бэлтгэн нийлүүлсэн ноолуурыг угааж нэмүү өртөг шингээн дотоодын зах зээлийн ханшнаас 30 хувиар илүү үнээр борлуулж дэлхийн зах зээлд таниулснаар Франц улсын Hermes групптэй "Бүтээгдэхүүн нийлүүлж гадаадад борлуулах" 3 жилийн гэрээ байгуулсан.		
9	3. Хоршооны "Сайн засаглал"-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх.	3.1. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.	2020 - 2024			Энэ жил "Цармын цагаан сувд", "Баянговь цагаан ямаат", "Залаа шинэ Эргэлт", "Залаажинст торгон сүрэг" зэрэг хоршоодод малчид ноос, ноолуураа бэлтгэн нийлүүлсэн. "Цармын цагаан сувд" хоршоо нь гишүүн өрхийн нийлүүлсэн ноолуурыг угааж боловсруулан гадаадад нэмүү өртөг шингээн борлуулж байна. Гишүүн өрхүүдэд жил бүр ноолуурын ашиг хуваарилан ажилладаг.	50%	50%
10		4.1. Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан тусгай хөтөлбөр бүхий байнгын сургалт зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үе шаттайгаар явуулах	2020 - 2024			Тус суманд бүртгэлтэй Хөдөө аж ахуйн 9 хоршоонд Шинэ хоршоо хөдөлгөөний талаарх мэдээллийг цаг тухай бүр хүргүүлж "Цармын цагаан сувд" хоршооны дарга З.Амартүвшин, "Залаа шинэ эргэлт" хоршооны дарга О.Бямбатогоо, малчин Ш.Батнасан, "Залаажинст торгон сүрэг" хоршооны малчин Х.Дашпунцаг, "Өсөх Залаажинст" хоршооны гишүүн Ч.Уранбилэг нарыг Улаанбаатар хотод сургалтад хамрууллаа. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоол, "Шинэ хоршоо - Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг сургагч багш	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
						нартай хамтран хоршооны удирдлага, гишүүдэд Иргэний танхимд сургалт зохион байгуулсан. Хоршооны удирдлага, гишүүдэд тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч зөвлөн тусалж байна.		
11		4.3. Төр засгаас хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр батлан гаргасан бодлогын баримт бичгийг нийтэд танилцуулах, сурталчлах	2020 - 2024			Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай тогтоол, "Шинэ хоршоо - Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг сургагч багш нартай хамтран Иргэний танхимд 29 иргэнд, 1 дүгээр багийн ИНХ-д оролцсон 50 гаруй иргэнд, 2 дугаар багийн ИНХ-д оролцсон 137 өрхийн 205 иргэнд, 3 дугаар багийн ИНХ-д оролцсон 43 иргэнд, нийт 327 иргэнд танхимаар, хөдөө аж ахуйн 3 багийн малчин өрх бүрээр айлчлан мэдээлэл хүргэн гарын авлага материал тарааж давхардсан тоогоор нийт 1580 иргэдэд сурталчлан танилцуулсан.	90%	90%
12	3. Хоршооны "Сайн засаглал"-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх.	4.7. Хоршоог дэмжигч шилдэг төрийн түшээг сум, аймгийн түвшинд тодруулан өргөмжилж байх	2020 - 2024			Хоршоог дэмжигч шилдэг төрийн түшээг жилийн эцэст шалгаруулна.	30%	30%

БАЯНХОНГОР АЙМГИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ - ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	ЗУРГАА. ХҮЛЭМЖИЙН ХИЙГ	6.5. Айл өрх, албан байгууллагын	2018 - 2028	16981120		"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулж, 160 гаруй иргэн хамрагдаж, нийт 14800 ширхэг модны	90%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
	БАГАСГАСАН, БҮС НУТГИЙН БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ, СЭРГЭХ ЧАДАВХИД НИЙЦСЭН ДЭД БҮТЭЦ, ХҮН АМЫН СУУРЬШЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.	хашаа, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, сумын төв, хот, суурин газруудыг ногоон хот болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн хувийн хөрөнгөөр тарьж ургуулсан ногоон байгууламж, тарьц, суулгац, ойжуулсан мод, бутыг тарьж ургуулсан иргэд, нөхөрлөл, бүлгүүдийг урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.				суулгацыг газрын хөрсөнд суулгасан дүнтэй байна. Үүнд "Сэкер ресорсус" ХХК 2500 суулгац, ЭрдэнэМонгол ХХК 11600, Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс 800 ширхэг суулгац, ЗДТГ-аас 860 ширхэг суулгацыг бэлтгэн шинээр тарьж, сумын хэмжээнд нийт 16560 ширхэг мод таригдлаа. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр байгалийн нөөцийн орлогын хэсгээр хамгаалалт хайс, хашаа тор, суулгац худалдан авч байгууллагуудад хариуцуулан тариулах ажлыг зохион байгууллаа.		
2	ДОЛОО. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙГ НОГООН	7.3. Аймгийн төр захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн	2018 - 2028	16981120		Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 60 сая төгрөгөөр байгаль орчинд чиглэсэн ажил үйлчилгээг хийхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Тендер зарлагдах шатандаа явж байна. Байгалийн нөөцийн орлогын хэсгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 56 сая	90%	30%

1	2	3	4	5	6	7	8	9
	ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, УЯН ХАТАН, ЧАДАВХТАЙ, ӨНДӨР БҮТЭЭМЖТЭЙ, ХҮНД СУРТАЛГҮЙ, ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ОЙРТУУЛСАН, ИРГЭДЭЭ НИЙГМИЙН САЙН САЙХАНД ХӨТӨЛСӨН ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ БАЙХААР ХӨГЖҮҮЛНЭ.	худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ худалдан авахад зарцуулна.				төгрөгийг зарцуулахаар төлөвлөгдөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2024 оны хагас жилд 16981120 төгрөгийг ургамалжуулах, биологийн нөхөн сэргээлтийн ажил арга хэмжээнд зарцуулаад байна.		

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА *О.т* Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Г.Батчимэг* Г.БАТЧИМЭГ

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
(Өөрийн үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 05

Залаа

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 28			
Үүнээс	Үр дүнтэй	100%	3
	Тодорхой үр дүнд хүрсэн	70-90%	22
	Эрчимжүүлэх шаардлагатай	30-50%	3
	Үр дүнгүй	0%	-
	Хэрэгжих хугацаа болоогүй	Х.Б	-
Дэд хөтөлбөрийн хагас жилийн хэрэгжилт 84 хувьтай байна.			

_____оОо_____

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 05

Залаа

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 28			
Үүнээс	Үр дүнтэй	100%	1
	Тодорхой үр дүнд хүрсэн	70-90%	10
	Эрчимжүүлэх шаардлагатай	30-50%	19
	Үр дүнгүй	0%	3
	Хэрэгжих хугацаа болоогүй	Х.Б	-
	Дэд хөтөлбөрийн хагас жилийн хэрэгжилт 70 хувьтай байна.		

_____оОо_____